



ХОТ БАЙГУУЛАЛТ,
БАРИЛГА, ОРОН
СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ

САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**“МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ
2025 он

“МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2025.12.23

НЭГ. ЗОРИЛГО

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-нд туссан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санал, зөвлөмж хүргүүлэх, холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдийг бодит мэдээллээр хангах, төрийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хариуцлагыг сайжруулах, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор хяналт-шинжилгээний ажлыг гүйцэтгэлээ.

Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг зорилтот түвшин, шалгуур үзүүлэлттэй уялдуулан хяналт-шинжилгээ хийж, дүгнэлт, зөвлөмж хүргүүлж байна.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-нд туссан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 25 тэргүүлэх чиглэл, 26 төсөл арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтэд 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийхэд тэргүүлэх чиглэл 90.74 хувьтай, төсөл арга хэмжээний хэрэгжилт 86.22 хувьтай, “үр дүн гарсан” гэж үнэллээ.

Хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт 26 төсөл арга хэмжээнээс хэрэгжилт 100 хувьтай 4, 90 хувьтай 6, 70 хувьтай 4, 50 хувьтай 5, 30 хувьтай 4, 0 хувьтай 3 арга хэмжээ байна.

Хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг төсөл арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин тус бүрээр харуулбал:

Д/д	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Төсөл, арга хэмжээний хэрэгжилт	Хувь
НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО					
	1.7.1.5. Цахилгаанаас үүдэлтэй гал түймэр гарах, цахилгаанд хүн цохиулахаас урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгох	1. Нам хүчдэлийн стандартыг шинэчлэн боловсруулах, сургах, хэрэгжүүлэх, мөрдөх, хянах	1	Тус ажлын хүрээнд “Цахилгаан техникийн ажил” /БНБД 3.05.06-90/ барилгын норм ба дүрмийг шинэчлэх болон “Орон сууц, олон нийтийн барилгын цахилгаан тоног төхөөрөмжийг төлөвлөх ба угсрах” барилгын дүрмийн төслийг боловсруулж Инженерийн байгууламж, шугам сүлжээний орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаан /01/2025, 02/2025/-аар хэлэлцүүлж, дэмжигдсэн. “Цахилгаан техникийн ажил” /БНБД 3.05.06-90/ барилгын норм ба дүрмийг шинэчлэх ажил нь ШУТТЗ-ийн 2025.08.27-ны өдрийн хурлаар хэлэлцэгдэж, дахин хэлэлцүүлэх шийдвэр гарсан. Зөвлөлийн гишүүдээс өгсөн санал, зөвлөмжийн дагуу барилгын норм ба дүрмийн төсөлд засвар өөрчлөлтийг хийж, ШУТТЗ-ийн хурлаар дахин хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж	95%

				байна. "Орон сууц, олон нийтийн барилгын цахилгаан тоног төхөөрөмжийг төлөвлөх ба угсрах" барилгын дүрмийн төслийг 2025.08.27-ний өдөр салбарын шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, гишүүдийн саналыг тусгахаар дэмжигдсэн. 2025.09.19-ны ШУТТЗ-ийн хуралдааны шийдвэрийг 07/3536 дугаартай албан бичгээр хүлээн авсан. Сайдын тушаалаар батлагдахаар хүлээлэгдэж байна.	
ХОЁР. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО					
	2.1.1.9. Хот төлөвлөлтийн бичиг баримтыг боловсруулахад оршин суугч, аж ахуйн нэгжийн саналыг тусгах, хөрөнгө оруулалттай уялдсан хот байгуулалтын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хууль, эрх зүйн шинэчлэлийн бэлтгэл ажлыг эхлүүлэх	1. Шинээр боловсруулах төлөвлөгөөний бичиг	5	1.Хот байгуулалтын тухай хууль (2008)-ийн 17 дугаар зүйл, ЗТБХБС-ын 2012 оны 183 дугаар тушаалаар батлагдсан "Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг олон нийтээр хэлэлцүүлэх журам"-ын дагуу хот байгуулалтын баримт бичиг боловсруулахад иргэд, олон нийтийн саналыг авч тусгах, холбогдох үе шатны хурлын хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Түүнчлэн хот байгуулалтын үйл ажиллагаанд оролцогч иргэн хуулийн этгээд, төрийн бусад байгууллагуудын чиг үүргийг нарийвчлан тусгах, иргэд олон нийтийн санал авах нарийвчлан зохицуулалтыг Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусган ажиллаж байна. Хуулийн үзэл баримтлалыг батлуулахаар 2025.11.27-ны өдрийн 01/4361 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн ба холбогдох хэлэлцүүлгийг зохион байгуулсан. 2.2025 онд нийт улсын хэмжээнд 6 хот, сууриний ерөнхий төлөвлөгөө боловсруулан батлуулсан. Үүнд: "Нью Урбанизм" ХХК-ийн боловсруулсан Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2025.12.03-ны өдөр, "Эрхэт констракшн" ХХК-ийн боловсруулсан Булган аймгийн Рашаант сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2025.06.27-ны өдөр, "Сонголт дизайн" ХХК-ийн боловсруулсан Өмнөговь аймгийн Булган, Ноён, Номгон сум төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2025.08.07-ны өдөр АИТХ-аар тус тус батлуулсан. Говь-Алтай аймгийн Алтай хот, Завхан аймгийн Дөрвөлжин, Ургамал, Сонгино, Тэлмэн сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслүүдийг боловсруулан, батлагдах шатандаа байна. Дээрх ерөнхий төлөвлөгөөний баримт бичгүүдэд Хот байгуулалтын тухай хуулийн 7.1.5-д заасны дагуу улсын экспертизийн дүгнэлт гаргахад иргэд, олон нийтээр хэлэлцүүлсэн талаарх тайланг авч хяналт, тавьж ажилладаг болно.	100 %
	2.1.2.6. Ногоон, уур амьсгалд дасан зохицох чадвар бүхий аймаг, сумдын төвийг хөгжүүлэх бүс нутгийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 1 дүгээр үе шатны төслийг хэрэгжүүлэх	1. Төслийн бэлтгэл ажлын явц	100	Тус хөтөлбөрийн үндсэн хэрэгжүүлэгч нь ЭЗХЯ бөгөөд ХББОСЯ нь хамтран хэрэгжүүлэгчээр оролцож байна. "Аймаг, сумын төвийн бүсчилсэн хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн I үе шатанд Баян-Өлгий, Увс, Ховд аймгууд хамрагдахаар төлөвлөгдсөн бөгөөд санамж бичгийн хүрээнд шийдвэрлэгдсэн Увс аймгийн Өмнөговь сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгаврын төсөлд 2025 оны 05/883 дугаартай албан бичгээр санал өгч, ЗТ-15/2025 дугаартай зургийн даалгаврыг Увс аймгийн Засаг дарга баталсан.	100 %

	2.3.1.1. Инженерийн дэд бүтцийг сайжруулах төслийг хэрэгжүүлэх	1. Төслийн бэлтгэл ажлын явц	100	Тус яамнаас гадаадын эх үүсвэрээр 10 сая төгрөгөөр хэрэгжих инженерийн дэд бүтцийг сайжруулах төсөл хэрэгжээгүй.	Х.Б
	2.3.1.2. 1000 айлын орон сууцны хорооллын гадна дулаан хангамжийн шугам сүлжээний бүтээн байгуулалтыг хийх	1. Дэд бүтцийн бүтээн байгуулалт	60	Төсөл арга хэмжээний гүйцэтгэгч “Чандмань тал” ХХК-тай 2024.09.13-аас 2026.10.30-ны өдөр хүртэл хэрэгжих нөхцөлтэй, 17,354,573 төгрөгийн үнийн дүнтэй гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээний хүрээнд дараах барилга угсралтын ажлыг гүйцэтгэхээр төлөвлөсөн. Үүнд: - УДД төвийн барилга: 12.0 м x 12.0 м хэмжээтэй; - Дулаан хангамжийн шугам: нийт урт L=8,150.0 м; - Гадна цахилгааны шугам: нийт урт L=520.0 м. Төслийн нийт санхүүжилт 10,856,861,177 төгрөг бөгөөд үүнээс: - 2024 онд 5,393,561,177 төгрөг, - 2025 онд 5,463,300,000 төгрөгийг санхүүжилт тус тус олгогдсон. 2025 оны 12 дугаар сарын байдлаар барилга угсралтын ажил 65%-ийн гүйцэтгэлтэй, төлөвлөсөн хугацааны дагуу хэвийн үргэлжилж байна.	100 %
	2.3.1.3. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжих 1800 айлын “Эко яармаг-1” төслийг хэрэгжүүлэх	1. Барилгын ажлын гүйцэтгэл	30	Улсын төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа Наадамчдын зам дээгүүр барих 800у/м гүүрэн байгууламж төслийн талбайтай дахцаж байгаатай холбоотойгоор ТОСК, замын зураг төсөл боловсруулж байгаа байгууллага, Төслийн зураг төсөл боловсруулсан байгууллагыг холбон 2 удаагийн зөвшилцөх уулзалт хийж, төслийн барилгажилтын ерөнхий төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан төслийг НАЗХГ-тай зөвшөөрөлцсөн бөгөөд нийслэлийн Ерөнхий архитектороор хянуулан баталгаажуулахаар хүргэгдсэн. Төслийн төлөвлөлтийн дагуу гадна цахилгаан хангамжийн сүлжээний чиглэл, зурвас өөрчлөгдсөнтэй холбоотойгоор гадна цахилгаан хангамжийн ажлын зураг төсөл дахин боловсруулагдсан. Эрчим хүчний яамнаас Цахилгаанаар хангах техникийн нөхцөл хүлээгдэж байна. Төслийн хэмжээнд 2025 оны хагас жилийн байдлаар газар чөлөөлсөн 26 нэгж талбарын иргэдээс 2025 оны 1 дүгээр улиралд түр суурьшуулах зардал болох 25 иргэнд 360.0 сая төгрөгийг олгоод байна. 3 нэгж талбар төсөлд огт хамрагдаагүй ба 15 нэгж талбартай 3 талт гэрээг нэмж байгуулахаар ажиллаж байна. “Анод Катод”ХХК төслийн гадна инженерийн 1-р хэлхээний шугам сүлжээний зураг төсөл гүйцэтгэж байгаа бөгөөд цахилгаан хангамжийн зураг төсөл магадлалд хянагдаж байна. Бусад инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл 2022 онд магадлалаар хянагдсан. Төслийн эхний ээлжийн барилгажих талбайн 64 нэгж талбарын 2.6 га газарт чөлөөлөлт хийгээгүй байгаа 16-р гудамж 586 тоотын иргэн П.Алимаатай тохиролцохоор ажиллаж байна. Төслийн шинээр боловсруулсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний загвар зургийг Нийслэлийн ерөнхий архитектортой зөвшилцөн 2025.04.04-ний өдөр загвар зураг төслийг батлуулсан.	

				Цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийн сунгалт хийгдэж, ус хангамж, ариутгах татуурга, мэдээлэл холбооны техникийн нөхцөлүүдийг шинээр шинэчлэн гаргуулан авсан. Төсөл хэрэгжүүлэгч “UB group” болон “Түм арвижих” ХХК-ийн түншлэлтэй байгуулсан гэрээний хугацааг сунгасан.	
	2.3.1.4. Иргэдийг орон сууцжуулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, эрх зүйн орчныг сайжруулах	1. Хуулийн төсөл	5	Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу Үндэсний орон сууцжуулалтын анхдагч хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг Сангийн сайд, Хууль зүй дотоод хэргийн сайд, Гэр бүл хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдаар батлуулахаар хүргүүлснээс Гэр бүл хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдаас батлан ирүүлэх хүлээгдэж байна. Хуулийн төслийг ХББОСЯ-ны https://mcud.gov.mn/forum/42 цахим хаягт байршуулан иргэд олон нийтээс санал авч байна. Барилгын үндэсний ассоциаци ТББ, аймаг нийслэлийн ерөнхий архитекторуудад хуулийн төслийг танилцуулан хэлэлцүүлсэн. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025.07.28-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 45 дугаар захирамжийн дагуу иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, орлоготой нийцсэн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд орон сууцны санхүүжилтийн тусгай чиг үүрэг бүхий банк байгуулах асуудлыг судалж, санал дүгнэлт боловсруулах Ажлын хэсгийг байгуулан холбогдох судалгааг хийсэн. Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2025 оны 112-р тушаалаар МУ-ын Ерөнхий сайдын 45 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх, орон сууцжуулалтын банкны тухай хуулийн төслийг боловсруулан танилцуулах чиг үүрэг бүхий дэд ажлын хэсгийг ХББОСЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулан байгуулж, орон сууцжуулалтын тухай болон орон сууцны санхүүжилтийн тухай хуулийн төсөл боловсруулан Ажлын хэсгийн дэд дарга Л.Энх-Амгаланд 2025.11.25-ны өдөр, Ерөнхий сайдад 2025.12.05-ны өдөр тус тус танилцуулаад байна.	30%
	2.3.1.5. “Миний амины орон сууц” хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын иргэдэд эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барьсан тохиолдолд 30 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх	1. Дэмжлэгийн хүрээнд баригдах амины орон сууц	1000	Эрчим хүчний хэмнэлттэй хувийн сууцны урьдчилгаа төлбөрийн татаасын санхүүжилтийн журмын зорилго нь хот суурин газрын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан амины орон сууцны бүсэд эрчим хүчний үр ашигтай хэрэглээг дээшлүүлэх, барилгын салбарт эрчим хүчний хэрэглээг бууруулахад урьдчилгаа төлбөрийн татаас бүхий эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барих болон сайжруулахад 30 хүртэлх сая төгрөгийн татаас олгох нөхцөл, шаардлагыг тодорхойлох, татаасын санхүүжилтийг олгох, зарцуулах, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах 6 бүлэгтэй “Амины орон сууц шинээр барих болон сайжруулахад төрөөс татаас олгох журам”-ын төслийг боловсруулан ХББОСЯ-ны цахим хуудаст байршуулан санал авч байна. Одоогийн байдлаар байгууллагын албан хаагчдаас 2 санал ирүүлсэн байна. Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөлд Улаанбаатар хотод 60 гаран мянган өрхийн багтаамжтай сайжруулсан гэр хорооллын бүсийг	0%

				тогтоосон байгаа бөгөөд Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөл УИХ-аар хэлэлцэгдэх хүлээгдэж байна. Тус яамнаас Орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл боловсруулж байгаатай холбогдуулан журмын төсөлд өөрчлөлт орж байгаа тул эдгээр хуулийн төслийг дагалдуулан журмын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар төлөвлөн ажиллаж байна.	
	2.3.1.6. “Миний сонголт-Орон нутаг” хөдөөгийн сэргэлтийн хүрээнд хэрэгжүүлж буй гурван хувийн хүүтэй ипотекийн зээлийн хөтөлбөрийг эхний гурван жилд хэрэгжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх	1. Хөтөлбөрт хамрагдах өрх	4762	“Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2023 оны 68 дугаар тогтоолын 1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг бууруулж, орон нутагт шилжин суурьшиж байгаа болон 21 аймаг, нийслэлийн алслагдсан Багахангай, Багануур, Налайх дүүрэгт оршин сууж байгаа төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн зээлд анх удаа хамрагдаж байгаа иргэдийг дэмжиж, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшиж буй болон орон нутгийн байнгын оршин суугч иргэний тухайн орон нутгаас анх удаа, шинээр худалдан авч буй орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хүү жилийн 6 хувь бөгөөд эхний 3 жилийн хүүгийн 50 хувь буюу 3 нэгж хувийг Засгийн газраас татаас хэлбэрээр дэмжлэг үзүүлж, хүүгийн зөрүү мөнгөн хөрөнгийг Засгийн газраас хариуцан төлж байна. Энэ хүрээнд “Ипотекийн зээлийн орон нутгийн орон сууцны санхүүжилтийн ерөнхий гэрээ”-г ХББООС-ын сайд, Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгч, арилжааны банкууд, Зээлийн батлан даалтын сантай байгуулан 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталсан. 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар орон нутагт 3,217 зээлдэгчид нийт 375.01 тэрбум төгрөгийн ипотекийн зээл авснаас 843 зээлдэгчид нийт 98.3 тэрбум төгрөгийн 3 хувийн ипотекийн зээл олгосон байна. 3 хувийн ипотекийн зээл олгож эхэлсэн 2023 оноос хойш нийт 4,810 зээлдэгч тус хөтөлбөрт хамрагджээ. Зээлийн батлан даалтын сангаас урьдчилгаа ипотекийн төлбөрийн батлан даалтад 2025 онд 281 зээлдэгч 6.02 тэрбум төгрөгийн батлан даалт гаргуулсан байна. Ипотекийн төлбөрийн батлан даалт гаргаж эхэлсэн 2023 оноос нийт 1,557 зээлдэгчид батлан даалт гаргасан байна.	73%
	2.3.1.8. “Миний сонголт-Төрийн алба” орон нутагт төрийн албан хаагчдын түрээсийн орон сууц барих төслийг хэрэгжүүлэх	1. Төрийн албан хаагчдын орон сууц	240	Засгийн газрын 2023 оны 483 дугаар тогтоолоор орон сууцжуулах чиглэлээр: 1. 2024 онд хэрэгжүүлж эхлээд байна. 8, 15 айлын орон сууцны төслийн үр дүнд: Төрийн албан хаагчдын 8 айлын 12 байршилд 96 төрийн албан хаагчийн орон сууцны барилгын ажил Архангай аймгийн Эрдэнэмандал суманд “Өлзий тээл” ХХК-ийн гүйцэтгэл 100% комисс ажиллуулах хүсэлт өгсөн, Баянхонгор аймгийн Богд суманд “Гал гэрэл констракшн” ХХК-30% ,Булган аймгийн Хутаг-Өндөр сум комисс ажилласан, "Инфинити пийк" ХХК-100%, Говь-Алтай аймгийн Бугат “Дрийм лево хаус” ХХК -80%, Дорнод аймгийн Баян-Уул комисс ажилласан,"Мишээл кристал хаус" ХХК-100%, Дундговь аймгийн Эрдэнэдалай "Миний хүлэг" ХХК-80%, Өвөрхангай аймгийн Сант "Изо хаус" ХХК-95%, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд "Их шовх" ХХК-100% комисс ажиллуулах	7%

				хүсэлт өгсөн, Төв аймгийн Баянчандмань суманд "Смарт технологи" ХХК-100% комисс ажиллуулах хүсэлт өгсөн, Ховд аймгийн Дарви суманд "Уран минж хийц" ХХК-20%, Хөвсгөл аймгийн Тариалан суманд "Идеал групп" ХХК-70%, Хэнтий аймгийн Жаргалтхаан суманд "Баруун урт констракшн" ХХК-70% 2025 онд ашиглалтад оруулахаар гүйцэтгэл 80%-тай ажиллаж байна. 2. 2025 онд 2025-2027 онд 18 аймгийн 64 сумын төв, нийслэлийн алслагдсан 2 дүүрэгт 8, 15 айлын төрийн албан хаагчдын орон сууц төсөл хэрэгжүүлэхээр 20 багц тендер зарлагднаас Увс, Хөвсгөл, Завхан, Сэлэнгэ, Дархан-Ууд, Өмнөговь аймгуудад гүйцэтгэгч шалгараагүй, оролцогч оролцоогүй бөгөөд Төсвийн хэмнэлтийн тухай хуульд зааснаар хөрөнгө татагдан амжилтгүй болсон. 16 багц тендерт гүйцэтгэгч шалгаран гэрээ байгуулж, ажил эхлээд 17 байршилд 15 айл, 27 байршилд 8 айлын 44 байршилд 14792м2 сууцны талбайтай 471 төрийн албан хаагчдын орон сууцны барилгын ажлын гүйцэтгэгтгэл 40%-тай байна. Төслийн үр дүнд 17 байршилд 15 айл, 39 байршилд 8 айлын Нийт 56 байршилд 24381м2 сууцны талбайтай 567 төрийн албан хаагчдын орон сууцны барилга баригдаж байна. НИЙТ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ 7%-ТАЙ БАЙНА. Комисс ажилласан 2 сум, комисс ажиллуулахаар хүсэлтээ өгсөн 3 сум. Төслийн үр дүнд 19 байршилд 15 айлын, 39 байршилд 8 айлын нийт 57 байршилд 25671м2 сууцны талбайтай 597 төрийн албан хаагчдын орон сууцны сантай болж хөдөө орон нутагт ажиллах төрийн албан хаагчдыг төрийн албан хаагчийн түрээсийн орон байраар хангаж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэх юм. 2025 онд нийт 80 төрийн албан хаагчдын орон сууцыг ашиглалтад оруулж 517 төрийн албан хаагчдын орон сууц 2027 оныг хүртэл хугацаагаар үргэлжилнэ	
	2.3.1.9. Бага, дунд орлоготой иргэдийн төлбөрийн чадварт нийцсэн 5616 айлын орон сууц барих төслийг хэрэгжүүлэх	1. Арга хэмжээний хэрэгжилт	30	"Төслийн гадна дулааны шугам сүлжээний барилга угсралтын ажлыг улсын төсвийн санхүүжилтээр ""Одкон холдинг"" ХХК үргэлжүүлэн 85 гүйцэтгэлтэй хийгдсэн. Зам сэтлэн 3 байршилд нэвтрэлттэй суваг хийх ажлаас 2 байршилд бүрэн дуусч 1 байршилд нэвтрэлттэй суваг хийх ажил хүлээгдэж байна. 2025 онд ашиглалтад оруулна. Гүйцэтгэл-95% Би Эс Би ХХК-ийн гүйцэтгэж байгаа гадна цахилгааны шугам сүлжээний барилга угсралт 2025 онд хүлээлгэж өгөхөөр төлөвлөгөөний дагуу 85%-ийн гүцэтгэлтэй үргэлжилж байна. ""Алтайн үндэс"" ХХК-ийн гүйцэтгэж байгаа гадна ус хангамж, ариутгах татуургийн шугам сүлжээний угсралтын ажлын 2 ш насос суурилуулах ажил үргэлжилж байна. Гүйцэтгэл -90% Биг монголиа бюлдинг ХХК ИШС-ний хонгилын системийн барилга угсралт 2025 онд ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй 87%-ийн гүйцэтгэлтэй ажил үргэлжилж байна. Нийт гүйцэтгэл 90%-тай хэвийн үргэлжилж байна. Орон сууцны "Залуус" хорооллын эхний ээлжийн 936 айлын орон сууцны төслийг гадаад дотоодын хөрөнгө оруулагч нарт танилцуулах, санал авах	70%

				ажлын хүрээнд Турк, Хятад улсын барилгын төсөл хэрэгжүүлэгч 3 байгууллагатай ХББОС-ын сайдын хийх уулзалт зохион байгуулсан. БНХАУ-ын ӨМӨЗО-ны барилгын 3 аж ахуйн нэгжийн хамтарсан нэгдэлтэй уулзалт хийж санал солилцсон. Залуус төслийг нийслэлийн замын сүлжээтэй холбохтой холбоотой санал, тодотголыг 2025.03.21-ний 04/1001 албан бичгээр нийслэлийн ХБХСГ, ЗХГ-т тус тус хүргүүлж нийслэлийн замын ажлын даалгаварт оруулсан. Засгийн газрын 2025.05.21-ний өдрийн хуралдаанд “Залуус-1” төслийн хэрэгжилтийн талаар танилцуулж, хуралдааны тэмдэглэлээр төслийг хамтран хэрэгжүүлэх чиглэлээр гадаадын хөрөнгө оруулагчдаас ирүүлсэн саналыг судалж, хамгийн үр ашигтай санал ирүүлсэн хөрөнгө оруулагчтай хэлэлцээр хийж төслийг эхлүүлэх арга хэмжээг авахыг тэмдэглэлээр даалгасан.”	
	2.3.1.10. Бага, дунд орлоготой иргэдийн төлбөрийн чадварт нийцсэн 5002 айлын “Солонго-I, II” орон сууцны хорооллын төслийг хэрэгжүүлэх	1. Ашиглалт ад орох орон сууц	45	Төслийн талбайн доторх замыг хотын замын сүлжээтэй холбох авто замын “Авто зам, замын байгууламжийн ажлын зураг төсөл боловсруулах” ЗД2025/01 дугаартай зургийн даалгаврын төслийг нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Замын хөгжлийн газраас санал авч боловсруулан ХББОСЯ-ний ТНБД-аар батлуулсан. Батлагдсан зургийн даалгаврын дагуу зураг төслийг боловсруулах санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр 2025.05.19-ний өдрийн 01/1856 тоот албан бичгээр ЭЗХ-ийн Сайдад хүргүүлсэн. “Солонго-1, 2” 5002 айлын орон сууцны төслийн эхний ээлжийн 980 айлын орон сууцны барилгыг 2025 оны 11 дүгээр сард ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй барилга угсралтын ажил хэвийн үргэлжилж байна. 980 айлын орон сууцны барилгын ажил 80%, Эхний ээлжийн 35 блок барилгаас 33 блок барилгын каркас угсралтын ажил бүрэн дуусаж, 19 барилгын цонх суулгалт, гадна фасадын дулаалгын ажил хийгдэж, 22 барилгын дээврийн дулаалга, 35 барилгын суурийн буцаан булалтын ажлууд тус тус бүрэн дууссан. Бусад гадна, дотор өрлөгө, тохижилтын ажил хийгдээд улсын комисс хүлээн авах бэлтгэл ажил хангагдан ажиллаж байна.	80%
	2.3.1.11. 1008 айлыг түр суурьшуулах орон сууцны төслийг хэрэгжүүлэх	1. Төслийн хэрэгжилт	100	БНХАУ-ын буцалтгүй тусламжаар Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн “Ногоон нуур” 1008 айлын орон сууцны цогцолборын барилга угсралтын ажил дуусч ашиглалтад оруулсан.	100 %
	2.3.1.12. Улаанбаатар хотын ногоон орон сууц төслийг хэрэгжүүлэх	1. Төслийн хэрэгжилт	100	Төслийн хүрээнд тогтвортой хөгжлийн 37 гүйцэтгэлийн үзүүлэлт (KPI) бүхий ногоон орон сууцны барилгын техникийн шаардлагыг хангасан, мөн Олон улсын ногоон барилгын үнэлгээний EDGE системийн шалгуурын дагуу 800 айлын орон сууцны барилга болон ухаалаг удирдлагын СКАДА төвийн барилгын нарийвчилсан зураг төслийг боловсруулж, холбогдох мэргэжлийн байгууллагууд болон магадлалаар хянуулан батлуулсан. Баянхошуу дэд төвд баригдаж буй эхний ээлжийн 110 айлын ногоон орон сууцны 4 блок барилга угсралтын ажил бүрэн дуусч, 2025	80%

				оны 09 дүгээр сарын 17-ны өдөр үүрэг даалгаврын биелэлттэйгээр барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах улсын комисст хүлээлгэн өгсөн ба 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн БА-311/2025 дугаар барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гарсан. Тус дэд төвийн инженерийн шугам сүлжээний барилга байгууламжийн ажлын явц 100 хувийн хэрэгжилттэй, улсын комиссд 2024 оны 12 сарын 26-нд хүлээлгэн өгсөн. Харин Баянхошуу дэд төвд 2024 оны 7 сараас эхлүүлсэн 226 айлын ногоон орон сууцны барилга угсралтын ажил 68 хувьтай хэрэгжиж байна. Баянхошуу дэд төвийн барилгуудыг EDGE стандартын шаардлагыг хангасан байдалд эрх бүхий Sintali” Ltd аудит хийсэн ба 2025 оны 8 дугаар сарын 13-нд B15 талбарын 4 блок барилгууд нь EDGE стандартыг зураг төслийн шатанд хангасан болохыг батлан GP1-MNG-23112910179665-110-P дугаартай EDGE гэрчилгээ олголоо. Аудитын явцад тус төслийн эрчим хүчний хэмнэлт - 34%, Усны хэмнэлт - 20%, Материалд шингэсэн хүлэмжийн хийн хэмнэлт - 21% гэж үнэлэгдсэн болно.	
	2.3.1.23. Барилгын салбарт шинэ инновацлаг бараа материал, угсралтын арга барилыг хурдацтай нэвтрүүлэх зорилгоор хот байгуулалт, зураг төсөл, барилгын ажлын стандарт, норм, дүрмийг боловсронгуй болгох судалгааны ажлыг барилга байгууламжийн норм, нормативийн сангийн санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлэх	1. Судалгааны ажлын хэрэгжилт	0	Хот байгуулалт, барилгын салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 409 барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт үзлэг хийх ажлыг барилга байгууламжийн норм, нормативын сангийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган батлуулж, ажлын техникийн даалгаврын төслийг боловсруулсан. Мөн 2025 онд барилга, байгууламжийн норм, нормативын баримт бичгийг үргэлжлүүлэн шинэчлэх /68/ болон шинээр боловсруулах /49/ нийт 117 ажлыг төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. Хэрэгжилт 100% “Барилгын мэдээлэлтэй загварчлал-BIM”-ийг нэвтрүүлэх 2025.06.04 өдрийн A/102 дугаартай Ажлийн хэсэг байгуулсан. Мөн 2025.11.24-ний өдөр Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын элчин сайдын яамны төлөөлөл, стандартын газар, хувийн хэвшлийн төлөөллүүдтэй уулзалт зохион байгуулж, 2025.11.27-ны өдөр Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс–Монголын Дэд бүтцийн форум: Дижитал бүтээн байгуулалт арга хэмжээний зохион байгуулсан. 2025.11.18-ний өдрийн 2025/22 дугаараар “BIM гарын авлага: эзэмшигч, дизайнер, инженер, гүйцэтгэгч, байгууламжийн менежерүүдэд зориулсан барилгын мэдээллийн загварчлалын гарын авлага”-ыг орчуулах, оюуны өмчийн эрхийг худалдан авах, хэвлэх ажлын техникийн даалгавар, 2025.11.18-ны өдрийн 2025/21 дугаар, “Барилга, барилгын ажлын талаарх мэдээллийг зохион байгуулах, дижитал болгох, үүнд барилгын мэдээллийн загварчлал (BIM)-ын загварчлалыг ашиглан мэдээллийн менежмент” ISO 19650 стандартчлах техникийн даалгавар, 2025.11.23-ны өдрийн 2025/24 дугаар “Барилга, байгууламжийн менежментийн салбарт мэдээлэл солилцоход зориулагдсан аж үйлдвэрийн суурь анги” ISO 16739 стандартын техникийн даалгавар тус тус батлуулж “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-т 2025.11.28-ны өдрийн 02/4390 дугаар албан	100 %

				бичгээр хүргүүлсэн. “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-аас гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендерийн зарыг цахимд байршуулсан.	
	2.3.2.1. “Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц” төслийг үргэлжлүүлэх /Шугам сүлжээ/	1. Дэд бүтцийн бүтээн байгуулалт	30	1. Тус яамны захиалгатай “Шинэ зуунмод” хотын эхний ээлжийн цахилгаан хангамжийн ажил-Хөндий 35кВ ЦДАШ, 35/10кВ-ын 2х10000кВА чадалтай “Хөндий” дэд станц, 110/35/10кВ-ын “Зуунмод” дэд станцын өргөтгөл /Төв/ шугамын барилга угсралтын ажил дууссан. 2025 оны 08 сарын 27-ны өдрийн 26/2025 дугаартай улсын комиссоор ашиглалтад оруулсан. Гүйцэтгэл-100% 2. АХБ-ны техник туслалцааны хүрээнд хэрэгжүүлсэн “Хөшигийн хөндийд байгуулагдах даван туулах чадвартай, ногоон шинэ хотын дэд бүтцийг хөгжүүлэх бэлтгэл хангах төсөл (ТА-10059 MON)”-ийн техник, эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/-ийн сүүлийн шатны тайланг хүлээн авсан. Тус яамнаас төслийн ТЭЗҮ-ийг хүлээн авахтай холбогдуулан АХБ-ны төлөөлөлтэй 2025.03.27 болон 2025.04.02-ны өдрүүдэд ажлын уулзалтыг хийж, тайлангийн үр дүнг хэлэлцсэн. БОУАӨЯ-аар уг төслийн ТЭЗҮ-ийн байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлтийг гаргуулж, 2025.05.06-ны өдрийн 12/2243 дугаар албан бичгээр хүлээн авсан.	100 %
	2.3.2.3. Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн ариутгах татуургын шугам сүлжээний бүтээн байгуулалтыг эхлүүлэх	1. Барилгын ажлын гүйцэтгэл	30	Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн ариутгах татуургын шугам сүлжээний худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны газраас зарлагдсан боловч гүйцэтгэгч шалгараагүй байна. Сангийн сайдын 2025.06.02-ны өдрийн 01/5252 тоот албан бичгийн дагуу тендер шалгаруулалтын зогсоосон.	0%
	2.3.2.4. Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хот байгуулахад шаардлагатай төлөвлөлт, бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	1. Арга хэмжээний хэрэгжилт	20	1. Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлалыг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 2025.04.09-ний өдрийн 165 дугаар тогтоолоор зөвшөөрөгдсөн. Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний 2025.04.11-ний өдрийн 2025/10/01 дугаартай ажлын даалгаврыг боловсруулж ХББОС-ын сайд, Хархорум хотын Захирагч нараар хамтран батлуулсан. Уг хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг ТХААГ-аас 2025.04.22-05.21-ний хооронд зарлаж нээлтийг хийсэн. Гэвч тендерт оролцогчийн санал нь шаардлага хангаагүй тул 2025.05.29-ний өдөр дахин зарласан бөгөөд 2025.06.27-ны өдөр лахин нээсэн боловч төсвийн тухай хуулиар санхүүжилт нь татагдсан. Хархорум хотын ЗАА-аас тус хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаврыг дахин боловсруулж холбогдох байгууллагуудаар хэлэлцүүлэх ажлын хүрээнд тус яамны ШУТТЗХ-аар 2025.12.05-ны өдөр хэлэлцүүлж, дэмжигдсэн. 2. “Шинэ Хархорум” хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай Археологийн хайгуул судалгааны ажлын эцсийн тайланг ССАЖЗЯ-ны дэргэдэх “Археологийн мэргэжлийн зөвлөл”, “Палеонтологийн мэргэжлийн зөвлөл”, “Соёлын биет бус өвийн	100 %

			мэргэжлийн зөвлөл"-ийн 2025.06.30-ны өдрийн хурлаар тус тус хэлэлцүүлэн дэмжигдсэн. Гүйцэтгэгчийн эцсийн тайланд захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн тухай "Хархорин" хотын ЗАА-ны 2025.08.20-ны өдрийн 2024/14 дугаартай дүгнэлт, тайлан болон 2025.08.21-ний өдрийн 01/273 дугаартай албан бичгээр ирүүлсэн тайлбарыг үндэслэн гэрээг эцэслэн дүгнэсэн. 3. "Шинэ Хархорум" хотын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх ажлын эцсийн тайланг БХБЯ болон БОАЖЯ /хуучнаар/-наас хамтран баталсан 024/03 дугаартай ажлын даалгаврын дагуу БОУАӨЯ-ны дэргэдэх Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2025.05.21-ний өдөр хэлэлцүүлж, зөвлөмж, дүгнэлтийг гаргуулсан. Эцсийн тайланг ЗХХ дүгнэлт, актаар хүлээн авч, гэрээг дүгнэсэн. 4. Шинэ хотын дэд бүтцийн эх үүсвэрийн ТЭЗҮ-ийн эрчим хүчний эх үүсвэрийн ТЭЗҮ-ийг ЭХЯ-ны ШУТЗ-ийн 2025.05.30-ны өдрийн ээлжит Ү хуралдааны 22 дугаар тэмдэглэлээр дэмжиж батлагдсан. Цэвэрлэх байгууламжийг ТЭЗҮ-ийг БХТ-ийн 2025.07.08-ны өдрийн ЭЗ-001/2025 дугаартай магадлалын нэгдсэн дүгнэлт гарч, эцсийн тайланг ЗХХ дүгнэлт, актаар хүлээн авч, гэрээг дүгнэсэн. 5. "Шинэ Хархорум" хотын байр зүйн зураг зохиох, ортофото зураг үүсгэх ажлын эцсийн тайланг 2025.06.10-ны өдөр Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын төрийн архивд 2025/ГБЗЗ/11 дугаартай актаар 1:2000 масштабтай байр зүй, ортофото зургийн бүрэн тайланг хүлээлгэн өгсөн. ЗХХ байгууллагын дүгнэлтийн хамт, актаар хүлээн авч, гэрээг дүгнэсэн. 6. Шинэ Хархорум" хотын эхний ээлжийн авто зам, замын байгууламжийн ажлын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний тайланг ЗТЯ-ны ШУТЗ-аар хэлэлцүүлж, 20 км авто замын ажлыг дэмжиж, зураг төслийг магадлалын нэгдсэн дүгнэлтээр баталсан. Хотын дотор 30 км замыг хотын ХЕТ-тэй уялдуулах зөвлөмжийн дагуу хийгдсэн ажлын үнэлгээг тохиролцон, гэрээг эцэслэн дүгнэхээр шийдвэрлэсэн. 7. "Шинэ Хархорум" хотын хүн амын унд ахуйн зориулалттай газрын доорх усны эх үүсвэрийн эрэл хайгуулын судалгааны ажлын тайланг 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдөр Усны нөөцийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж дэмжигдсэн. Хархорум хотын хүн амын унд, ахуйн зориулалттай газрын доорх усны ордын нөөцийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/281 дүгээр тушаалаар баталсан. Эцсийн тайланд хийсэн захиалагчийн хяналтын дүгнэлт, тайланг хянаж, гэрээг дүгнэсэн. 8. 2025 онд УТХО-аар хэрэгжиж буй "Шинэ Хархорум" хотын II ээлжийн авто зам, замын байгууламжийн ТЭЗҮ, инженерийн нарийвчилсан зураг төсөл /Хархорин сум-Хөшөө цайдам-Өгийнуур-Дашинчилэн чиглэлийн замтай холбох/, "Шинэ Хархорум" хот дахь "Хэлтгий цагаан" нуур сэргээх, бохирдолт, ширгэлтээс хамгаалах судалгаа, зураг төсөл, Арвайхээр-Хархорум хот	
--	--	--	---	--

				чиглэлийн 220 кВ-ийн цахилгаан дамжуулах агаарын шугамын ажлын зураг төслийн ажлуудыг гэрээний дагуу дундын тайлангуудад ЗХХ дүгнэлт гаргуулан хүлээн авсан."Шинэ Хархорум" хотын унд ахуйн зориулалттай ундны усны эх үүсвэрийн эрэл-хайгуулын судалгаа хийх ажил нь эхний ээлжийн ажлын усны эх үүсвэр БОУАӨЯ-аас 8 сард батлагдсантай холбоотойгоор 1 дүгээр талбайн эхний ээлжийн ашиглалтын худаг, барилга байгууламжийн зураг төслийн ажил удааширч, 10 худгийн цооногийн өрөмдлөгийн ажил хийгдэж, хур тунадас, цаг агаарын нөхцөл хүндэрсний улмаас зогсолт хийсэн. Иймд дундын тайланг хийсэн ажлын гүйцэтгэлээр хүлээн авахаар шийдвэрлэсэн.	
	2.3.2.6. Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэх	1. Төслийн хэрэгжилт	25	Засгийн газрын 2025.01.14-ний өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэлээр Бүсийн зөвлөлүүдийг байгуулж, 2025 оны II улиралд багтаан бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдааныг зохион байгуулах болсны дагуу 2025.04.14-ний өдөр Хангайн бүс, 2025.04.28-ний өдөр Хойд бүс, 2025.05.12-ны өдөр Говийн бүсийн өргөтгөсөн хуралдаан болж, уг Засгийн газрын хуралдаанд орон сууц, нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн асуудлыг хэлэлцүүлж, Засгийн газрын 2025 оны 181, 182, 204, 209 дугаар тогтоолуудад салбарыг асуудлыг тусгуулсан. ХББОС-ын сайдын 2025.04.29-ны өдрийн 91 дүгээр тушаалаар нийслэлийн 3 дүүрэг, 10 аймаг 19 суманд инженерийн дэд бүтцийн нийт 22 ажил баталсан. Эдгээрээс орон нутгийн хөгжлийн төвүүдэд 2025-2027 онд нийт 167,485.5 тэрбум төгрөгийн өртөг бүхий төсөл, арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. 2025 онд хэрэгжих инженерийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын хүрээнд 41,551.4 тэрбум төгрөгийн санхүүжилттэй 22 ажилд гүйцэтгэгч шалгарч, гэрээний нийт хэрэгжилт 28%-д хүрээд байна. Тухайн оны гүйцэтгэл -100%.	100 %
ГУРАВ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО					
	3.2.1.10. Халаалтын урсгал зардал өндөртэй сургууль, цэцэрлэгийн барилгад эрчим хүчний аудитын үнэлгээг үе шаттай хийлгэх, шинээр барих барилгыг пассив барилгын шаардлагад нийцүүлэх, эрчим хүчний хэмнэлттэй технологид шилжүүлэх, бэлтгэл хангах	1. Эрчим хүчний аудитын үнэлгээ хийлгэсэн, сургалтын байгууллагын тоо	20	Пассив барилгын барилгын стандартын шаардлага боловсруулах ажлын техникийн даалгаврын төслийг боловсруулж, санал авахаар цахим системээр "Пассив барилгын хүрээлэн" ТББ-д хүргүүлсэн. Техникийн даалгавар батлуулснаар ажлын тоо хэмжээ тодорхой болж төсөв гарна. Барилга, хот байгуулалтын сайд, Эрчим хүчний сайдын хамтарсан 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/257, А/252 дугаартай тушаалаар батлагдсан "Барилгын эрчим хүчний гэрчилгээ олгох журам"-ын дагуу 319 барилгын зураг төсөлд 2025 оны эхний хагас жилийн байдлаар орон тооны бус экспертүүдээр хянагдаж, эрчим хүчний гэрчилгээ олгогдсон. Япон Улсын барилга, орон сууцны эрчим хүчний хэмнэлт, пассив болон ногоон барилга байгууламжид хэрэгжүүлж байгаа бодлого, норм норматив, техникийн зохицуулалт, стандарт, арга хэмжээ, ач холбогдол, үр нөлөөг судлах болон шинэ технологи, инновац, шилдэг жишээтэй танилцаж, туршлага судлах зорилгоор 2025 оны 12 дугаар сарын 06-14-ний өдрүүдэд томилолтоор ажиллах багийн бүрэлдэхүүн,	100 %

				удирдамжийг ТНБД-ын 2025.11.28-ны өдрийн Б/204 тоот тушаалаар баталсан. Тус баг нь ХББОСЯ, Барилгын хөгжлийн төв, Нийслэлийн ЗДТГ, МУИС-ийн багш, судлаач нараас бүрдсэн. Энэхүү арга хэмжээний үр дүнд барилгын эрчим хүчний хэмнэлт, пассив болон ногоон барилгын талаарх Японы туршлага, инновацийн шийдлүүдийг судалж, Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй норматив баримт бичгүүдтэй уялдуулах, нутагшуулах боломжийг тодорхойлон, норм норматив, стандартыг шинэчлэх, бодлогын баримт бичигт тусгах талаар салбарын мэргэжилтнүүд шинэ мэдлэг, ойлголт, ур чадвараа дээшлүүлсэн.	
ДӨРӨВ. ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО					
	4.6.1.6. Газар хөдлөлтийн гамшгийн үеийн удирдлага, хоргодох, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх зориулалт бүхий барилга байгууламжийг хүчитгэж, газар хөдлөлтийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх	1. Хүчитгэн засварлах барилга	5	“Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн 2 дугаар үе шатны төслийн хүрээнд боловсруулсан "Гамшгийн үед түр байраар ашиглах сургууль, цэцэрлэгийн төлөвлөлтийн гарын авлага", "Газар хөдлөлт тэсвэрлэлтийг хангах барилгын хүчитгэлийн үйл ажиллагааг зохион байгуулах заавар"-ыг ХББОСС-ын 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 238 дугаар тушаалаар батлуулсан. Шинээр болон шинэчлэн боловсруулсан “Өрөгт бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал” /БД 22-105-25/, “Цутгамал төмөр бетон бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал” /БД 22-106-25/, “Том хавтгаалжин угсармал бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал” /БД 22-107-25/, “Ган бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх заавар” /БД 22-108-2025/ барилгын дүрмийн төслийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн 2025 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, дэмжсэн шийдвэр гарсан. Хуралдааны шийдвэрийн дагуу санал, зөвлөмжийг тусган Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 261, 262, 263, 264 дүгээр тушаалаар тус тус батлуулсан. Энэхүү төслийн хүрээнд Эх нялхсын эрүүл мэндийн үндэсний төвийн Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлгийн барилгын хүчитгэлийн угсралтын ажил 2025 оны 06 дугаар сараас эхлэн хийгдэж байна.	100 %
	4.6.1.8. Монгол Улсын хэмжээнд газар хөдлөлтийн эрчмийг тодорхойлсон иж бүрэн зураглал хийх	1. Бичил мужлалын зураглал хийх аймаг	21	Өмнөговь аймгийн Даланзадгад, Хөвсгөл аймгийн Мөрөн сумын төвийн газар хөдлөлийн аюулын үнэлгээ ба бичил мужлалын судалгаа, зураглалыг Одон орон, геофизикийн хүрээлэн хийж гүйцэтгэсэн бөгөөд Шинжлэх ухааны академийн физик, математик, информатикийн салбарын бага чуулганы 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хурлаар дээрх аймгуудын судалгааны тайланг хэлэлцэж, зорилтоо биелүүлсэн гэх шийдвэр гарсан байна. Энэ зураглалын ажлыг “Инженер геологи, геотехник, барилга бүтээц, газар хөдлөлтийн арга хэмжээний орон тооны бус мэргэжлийн зөвлөл”-ийн 2025 оны 12 дугаар сарын	100 %

				төлөвлөгөөт хурлаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна.	
	4.6.1.9. Аймаг, нийслэлийн хэмжээнд 2002 оноос өмнөх нийт барилга байгууламжийг паспортжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх	1. Шинээр паспортжуулах барилга	100	Улсын Их Хурлын 2016 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай”-ын 1.5-т “орон сууц, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламжийн чанар, газар хөдлөлтөд тэсвэрлэх байдлыг шалгаж, барилга байгууламжийг паспортжуулах ажлыг 2017 онд багтаан дуусгах, газар хөдлөлтөд тэсвэргүй барилгыг буулгаж шинээр барих, ашиглах боломжтой барилгын судалгааг гаргаж, тэдгээрийг үе шаттайгаар бэхэлж хүчитгэх ажлыг зохион байгуулах;” гэж заасан бөгөөд Улсын хэмжээнд 130,000 гаруй барилга байгууламж ашиглагдаж байгаагаас 2002 оноос өмнө баригдсан 7631 /аймаг – 5787, нийслэл – 1844/ олон нийтийн зориулалттай барилга байгууламж байна. Сүүлийн жилүүдэд газар хөдлөлтийн идэвхжилт, эрсдэл нь 1.3-2.1 дахин өссөн байгааг харгалзан үзэж, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс улсын хэмжээнд ашиглагдаж буй 2002 оноос өмнө баригдсан сургууль, цэцэрлэг, эмнэлгийн зориулалттай 1760 барилга байгууламжийн бат бэх, найдваржилтийн төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гаргаж, паспортжуулах ажилд шаардлагатай 17,600,000,000 /арван долоон тэрбум зургаан зуун сая/ төгрөгийн асуудлыг Засгийн газрын нөөц сан эсхүл орон нутгийн гамшгаас хамгаалах төсвөөс гаргах шаардлагатай байгаа талаарх Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулаад байна. 2025 оны Нийслэлийн төсөвт нийт 20 барилга байгууламжийг паспортжуулах санхүүжилтийг тусган худалдан авах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Энэ ажлын хүрээнд “Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Барилга байгууламжийн ашиглалт (ногоон, шар, улаан)-ын гэрчилгээ загвар”-ыг нэмэлтээр боловсруулан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 118 дугаар тушаалаар батлуулж, Legalinfo.mn-д байршуулсан. 2025 онд дараах 4 барилгын паспортжуулалтын дүгнэлт гаргасан. Дурдвал: Төв аймгийн Баянцагаан сумын ерөнхий боловсролын сургууль, Засгийн газрын 12 дугаар байрны барилга /5 блок/, Барилгын хөгжлийн төвийн барилга, Улаанбаатар дулааны сүлжээ ТӨҮГ-ын төв байр болон соёлын төвийн барилга. Тагнуулын ерөнхий газрын Төв аймгийн Борнуур сумын нутагт байрлах "Ёл хад" нөхөн сэргээх төвийн барилгын паспортжуулалтын дүгнэлтийн ажил хийгдэж байна. Мөн Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар Улаанбаатар хотын хэмжээнд олон нийт, орон сууц, инженерийн дэд бүтцийн 23 барилга байгууламжийн паспортжуулалтын ажил хийгдэж байна. Дорноговь болон Дундговь аймгуудад шинээр баригдсан 4 барилгад ногоон гэрчилгээ олгогдсон байна.	100 %

	4.6.2.1. Улаанбаатар хотын шинэ төв цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулах	1. Барилгын ажлын гүйцэтгэл	100	“Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”-ийн барилга угсралт, цахилгаан хангамж, дэд станц, ус, дулааны шугам, УДДТ, холбооны шугам зэрэг дэд бүтцийн хангамжийн шугам сүлжээний ажил бүрэн дууссан. Дэд бүтцийн ажлуудыг улсын комисс хүлээн авсан. Төслийн барилга угсралтын ажил 98%-тай, 2025.07.24-ний өдөр хаягдал усыг хүлээн авч туршилт тохируулгын ажлыг эхлүүлэн өдөрт 50000 м.куб усыг MNS 4349-2015 стандартад нийцүүлэн цэвэрлэж байна. Цэвэрлэх байгууламжийн хэмжээнд 2025.09.29-ний өдөр техникийн комисс ажиллуулж, 12 дугаар сарын 01-ний өдрийн 05/2025 дугаар техникийн комиссын дүгнэлтээр улсын комисс ажиллуулах хүсэлтийг захиалагчид тавих зүйтэй гэж дүгнэсэн. 2025 оны 12 сард багтаан ашиглалтад оруулах улсын комисс ажиллуулахаар төлөвлөж байна. Төслийн хэрэгжилт 98%-тай байна.	95%
	4.6.2.4. Аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төслийг хэрэгжүүлэх	1. Төслийн хэрэгжилт	100	“Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих” төслийн Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 4200 м.куб/хоног хүчин чадалтай бохир ус цэвэрлэх байгууламжийн барилга, байгууламжийг 2025.06.11-ний өдрийн ББКД-83-0011/25 дугаартай комиссын дүгнэлтээр ашиглалтад оруулсан. Хэрэгжилт: 100% Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 2000 м3/хоног хүчин чадалтай бохир ус цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025.12.01-ний өдөр ажилласан. Хэрэгжилт: 97.11% Завхан аймгийн Улиастай сумын 3000 м3/хоног хүчин чадалтай бохир ус цэвэрлэх байгууламжийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг баталж, комисс 2025.11.17-ны өдөр ажилласан. Хэрэгжилт: 97.04% Увс аймгийн Засаг даргын 2025.11.19-ний өдрийн А/603 дугаар захирамжаар Увс аймгийн Улаангом суманд баригдсан хоногт 3000м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг баталж, комисс 2025.11.20-ны өдөр ажилласан. Хэрэгжилт: 96.27% Дорнод аймгийн 10,000 м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн ажлын зураг, төсөв Барилгын хөгжлийн төвийн 2025.09.02-ны өдрийн 1551/2025 дугаартай Барилга байгууламжийн зураг төслийн магадлалын дүгнэлтийн нэгтгэлээр батлагдсан. Хэрэгжилт - 33.3%-тай.	85%
	4.6.2.5. Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлэх	1. Төслийн хэрэгжилт	100	Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төслийн хүрээнд 17 байршлын 13,3 км хоолойн шинэчлэлийн угсралтын ажил бүрэн дууссан бөгөөд барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах Улсын комисс ажиллах бэлтгэл ажлыг хангаж ХББОС-ын сайдын 2025.11.11-ний өдрийн 01/4162 дугаар албан бичгээр Дархан-Уул аймгийн Засаг даргад Улсын комисс ажиллуулах хүсэлтийг хүргүүлсэн. Мөн 15000 ширхэг цэвэр усны ухаалаг тоолуур, холбох хэрэгсэл болон 17 ширхэг Гэйтвэй антенн авч, суурилуулахаас нийт 10000 ширхэг тоолуур, 17 ширхэг Гэйтвэй антенн суурилуулсан.	90%

				3-р ээлжийн 5000 ширхэг цэвэр усны ухаалаг тоолуур суурилуулах ажлыг эхлүүлэх бэлтгэлийг хангаад байна.	
	Хэрэгжилт				61%

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлийн хэрэгжилт

Үр дүнгүй, 0 хувьтай арга хэмжээ 3 байна. Үүнд:

- 2.3.1.1. Инженерийн дэд бүтцийг сайжруулах төслийг хэрэгжүүлэх.
Шалгуур үзүүлэлт: Төслийн бэлтгэл ажлын явц, хувь
Зорилтот түвшин: 100
- 2.3.2.3. Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн ариутгах татуургын шугам сүлжээний бүтээн байгуулалтыг эхлүүлэх.
Шалгуур үзүүлэлт: Барилгын ажлын гүйцэтгэл, хувь
Зорилтот түвшин: 30
- 3.2.1.10. Халаалтын урсгал зардал өндөртэй сургууль, цэцэрлэгийн барилгад эрчим хүчний аудитын үнэлгээг үе шаттай хийлгэх, шинээр барих барилгыг пассив барилгын шаардлагад нийцүүлэх, эрчим хүчний хэмнэлттэй технологид шилжүүлэх, бэлтгэл хангах.
Шалгуур үзүүлэлт: Эрчим хүчний аудитын үнэлгээ хийлгэсэн, сургалтын байгууллагын тоо
Зорилтот түвшин: 20

Эрчимжүүлэх шаардлагатай, 30 хувьтай арга хэмжээ 4 байна. Үүнд:

- 2.3.1.5. “Миний амины орон сууц” хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын иргэдэд эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барьсан тохиолдолд 30 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх.
Шалгуур үзүүлэлт: Дэмжлэгийн хүрээнд баригдах амины орон сууц, тоо
Зорилтот түвшин: 1000
- 2.1.2.6. Ногоон, уур амьсгалд дасан зохицох чадвар бүхий аймаг, сумдын төвийг хөгжүүлэх бүс нутгийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 1 дүгээр үе шатны төслийг хэрэгжүүлэх.
Шалгуур үзүүлэлт: Төслийн бэлтгэл ажлын явц, хувь
Зорилтот түвшин: 100
- 2.3.1.3. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжих 1800 айлын “Эко яармаг-1” төслийг хэрэгжүүлэх.
Шалгуур үзүүлэлт: Барилгын ажлын гүйцэтгэл, хувь
Зорилтот түвшин: 30
- 2.3.1.4. Иргэдийг орон сууцжуулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, эрх зүйн орчныг сайжруулах.
Шалгуур үзүүлэлт: Хуулийн төсөл, тоо
Зорилтот түвшин: 5

Эрчимжүүлэх шаардлагатай, 50 хувьтай арга хэмжээ 5 байна. Үүнд:

- 2.3.1.8. “Миний сонголт-Төрийн алба” орон нутагт төрийн албан хаагчдын түрээсийн орон сууц барих төслийг хэрэгжүүлэх.
Шалгуур үзүүлэлт: Төрийн албан хаагчдын орон сууц, тоо
Зорилтот түвшин: 240
- 2.3.1.12. Улаанбаатар хотын ногоон орон сууц төслийг хэрэгжүүлэх.
Шалгуур үзүүлэлт: Төслийн хэрэгжилт, хувь

Зорилтот түвшин: 100

3. 2.3.2.6. Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэх.

Шалгуур үзүүлэлт: Төслийн хэрэгжилт, хувь

Зорилтот түвшин: 25

4. 4.6.1.6. Газар хөдлөлтийн гамшгийн үеийн удирдлага, хоргодох, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх зориулалт бүхий барилга байгууламжийг хүчитгэж, газар хөдлөлтийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх.

Шалгуур үзүүлэлт: Хүчитгэн засварлах барилга, тоо

Зорилтот түвшин: 5

5. 4.6.1.9. Аймаг, нийслэлийн хэмжээнд 2002 оноос өмнөх нийт барилга байгууламжийг паспортжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх.

Шалгуур үзүүлэлт: Шинээр паспортжуулах барилга, тоо

Зорилтот түвшин: 100

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Монгол Улсын Их хурлын 2024 оны 35 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-нд туссан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 25 тэргүүлэх чиглэл 72 хувийн хэрэгжилттэй, мөн эрхлэх асуудалд хамаарах 26 төсөл арга хэмжээний хэрэгжилтэд 2025 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ хийхэд хэрэгжилт **61 хувь**, “**үр дүн хүлээгдэж байгаа**” гэж дүгнэж байна.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд захиалагч, хэрэгжүүлэгч байгууллагуудын удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах, бусад төрийн байгууллагуудтай ажлын уялдаа холбоог нэмэгдүүлэн хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай гэж үзэж байна.

ДӨРӨВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Төрийн нарийн бичгийн даргад зөвлөмж болгох нь:

1. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд туссан хагас жилийн байдлаар хэрэгжилт хангалтгүй 0-50 хувьтай 12 арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх болон тэргүүлэх чиглэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн, төсөл арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангуулах хүрээнд хангуулах хүрээнд зорилтот түвшинд чиглэсэн тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг бүх газар, хэлтсүүдэд үүрэг болгох;

1.1. Жилийн төлөвлөгөөний төсөл арга хэмжээний “2.3.1.1. Инженерийн дэд бүтцийг сайжруулах төслийг хэрэгжүүлэх” заалт нь гадаадын зээл эх үүсвэрээр 10 сая төгрөгөөр хэрэгжүүлэх гэж бодлогын баримт бичигт тусгагдсан боловч хэрэгжилтгүй байгаа тул тус яамны санал мөн эсэх, Эдийн засаг хөгжлийн яамнаас тодруулах цаашид хэрэгжилтийг хэрхэн хангуулах талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газар, Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газарт;

1.2. Төсөл арга хэмжээний 2.3.2.1. “Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц” төслийг үргэлжлүүлэх /Шугам сүлжээ/ нь Эрчим хүчний яамны сайдын багцаас хэрэгжүүлж байгаа төсөл эсэхийг тодруулан хэрэгжилтийн талаар Эдийн засаг, хөгжлийн яамтай зөвшилцөхийг Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газарт; /Ус хангамж, цахилгаан хангамж, инженерийн бэлтгэл арга хэмжээний эхний ээлжийн ажлууд 2022-2024 онд тус яамнаас хэрэгжиж ашиглалтад орсон./

1.3. Төсөл арга хэмжээний 3.2.1.10. Халаалтын урсгал зардал өндөртэй сургууль, цэцэрлэгийн барилгад эрчим хүчний аудитын үнэлгээг үе шаттай хийлгэх, шинээр барих барилгыг пассив барилгын шаардлагад нийцүүлэх, эрчим хүчний хэмнэлттэй технологид

шилжүүлэх, бэлтгэл хангах заалтын хэрэгжилтийг хангуулах, хариуцах нэгжийг тодорхой болгож, хэрэгжилтийг хангуулахыг Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газарт;

1.4. Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөний шалгуур үзүүлэлтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн болох “4.6. Орчны аюулгүй байдлыг хангана.”, шалгуур үзүүлэлт “орчны эрсдэлийн түвшин” 3 хувьд хүргэх үзүүлэлтийг холбогдох бодлогын газар, бусад байгууллагуудтай хамтран тооцож гаргахыг Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газарт;

1.5. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлийн 3.1.2.4. Үл хөдлөх салбарын хамтын хөрөнгө оруулалтын сангийн эрх зүйн орчныг бүрдүүлнэ. заалтын хүрээнд ажил хэрэгжүүлээгүй байх тул холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газарт тус тус үүрэг болгох;

2. Цаашид жилийн төлөвлөгөөний санал боловсруулах Ажлын хэсгийг цаглабарт хугацаанд байгуулж аргачлалын дагуу төлөвлөлтийг сайжруулах, суурь судалгаанд үндэслэх, зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг бусад бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан оновчтой, зөв тодорхойлох, саналыг хугацаанд нь хүргүүлэх, жилийн төлөвлөгөөний эцсийн төслийг Ажлын хэсэгт /газруудад/ эргэн танилцуулдаг байх, эрхлэх асуудлын хүрээнд хамаарахгүй төсөл арга хэмжээг тэр даруй хариу хүргүүлж байхыг Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газарт үүрэг болгох;

3. Батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх, нэгжийн төлөвлөгөөнд тусгаагүй ажлуудыг албан хаагч нь нэмэлт үүрэг даалгаварт оруулан хэрэгжүүлэх, хэрэгжилтийн тайланг үнэн зөв, товч, тодорхой, зарцуулсан санхүүжилт, нотлох баримтын хамт тогтоосон хугацаанд нь тайлагнаж хэвшихийг Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газар болон бусад газар хэлтсүүдэд үүрэг болгох нь зүйтэй байна.

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ,
САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР